



236

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэх тухай

Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор
ТУШААХ НЬ:

1.Халдварт саа өвчнийг устгасныг баталгаажуулах үндэсний хороог “Тарилгатай халдварт өвчний тандалтын ДЭМБ-ын зорилтын хэрэгжилтийг баталгаажуулах хороо” болгон өргөтгөж, хорооны шинэчилсэн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Тарилгатай халдварт өвчний тандалтын ДЭМБ-ын зорилтын хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Хорооны даргад даалгасугай.

3.Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-т даалгасугай.


4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 183 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н. УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03
дугаар сарын 07-өдрийн 77 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт




237

Тарилгатай халдварт өвчний тандалтын ДЭМБ-ын зорилтын
хэрэгжилтийг баталгаажуулах хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга:	ЭМЯ-ны Биотехнологийн ерөнхий мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт, судалгаа хариуцсан дэд захирал
Гишүүд:	ЭМЯ-ны Мэдрэл судлалын ерөнхий мэргэжилтэн ЭМЯ-ны Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн ЭМЯ-ны Халдварт өвчин судлалын ерөнхий мэргэжилтэн ЭМЯ-ны Тархвар судлалын ерөнхий мэргэжилтэн ЭМЯ-ны Дархлаа судлалын ерөнхий мэргэжилтэн ЭМЯ-ны Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн зохицуулагч НЭМҮТ-ийн захирал ЗӨСҮТ-ийн ерөнхий захирал ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн клиникийн дарга ЭМШУИС, Био-анагаахын сургуулийн бичил амь- дархлаа судлалын тэнхимийн зөвлөх профессор НЭМХ-ийн Полиомиелитийн үндэсний лавлагаа лабораторийн эрхлэгч ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга ХӨСҮТ-ийн Улаанбурханы Үндэсний Лавлагаа лабораторийн эрхлэгч ХӨСҮТ-ийн Халдвартын клиникийн зөвлөх ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны тандалт хариуцсан халдвар судлагч их эмч ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн (тохиролцсоноор)

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 07 ны өдрийн 7.1 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Тарилгатай халдварт өвчний тандалтын ДЭМБ-ын зорилтын хэрэгжилтийг баталгаажуулах Хорооны ажил үүргийн хуваарь

Нэг. Нийтлэг үүрэг

- 1.1. Хорооны ажлын төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжилтийг хагас жил тутам хорооны хурлаар хэлэлцэх,
- 1.2 Хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг тодорхой гаргах,
- 1.3.Тарилгатай халдварт өвчний тандалт ДЭМБ-ын бүсийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,
- 1.4.Тарилгатай халдварт өвчний тандалтын талаар хэрэгжүүлж буй стратеги төлөвлөгөө, тушаал, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж гаргах,
- 1.5.Хил залгаа улс орнуудад зэрлэг омгийн вирусээр үүсгэгдсэн полиомиелит болон улаанбурханы нутагшмал омгийн вирусийн өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд авах хариу арга хэмжээний талаар зөвлөмж гаргах.

Хоёр. Халдварт саа өвчнийг устгасныг баталгаажуулах талаар

- 2.1.Цочмог сул саажилт (ЦСС)-ын тандалт, халдварт саагийн эсрэг тархлаажуулалтын хамралтыг жилд 1 удаа хорооны хурлаар хэлэлцэн зөвлөмж гаргах,
- 2.2.Халдварт саа өвчнийг устгасан байдлаа хэвээр хадгалах талаар ЭМЯ-нд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх,
- 2.3.Халдварт саа өвчнийг устгасныг баталгаажуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн мэдээллийг холбогдох салбар, мэргэжилтнүүдэд тухай бүр нь мэдээлж байх,
- 2.4.Зэрлэг омгийн полиовирус зөөвөрлөгдөн орж ирсэн болон вакцины омгоор үүсгэгдсэн полио вирусийн халдвар илэрсэн тохиолдолд халдварын тархалтыг хязгаарлах, хариу арга хэмжээний бэлэн байдалд хяналт тогтмол тавих,
- 2.5.ЦСС-ын тандалт болон хүрээлэн буй орчинд зэрлэг омгийн полиовирус орчилдож байгаа эсэхийг тогтоох талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэн ДЭМБ-ын Номхон далайн баруун бүс /НДББ/-ийн хороонд жил тутам хүргүүлж байх,
- 2.6.ЦСС-ын хамшинжийн оношийг баталгаажуулах мэргэжлийн комиссын үүргийг хавсран гүйцэтгэх.

Гурав. Улаанбурхан өвчний тархалтыг эрс бууруулсныг
баталгаажуулах талаар



3.1. Улаанбурхан өвчний тархалтыг эрс бууруулах талаар холбогдох байгууллагуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах,

3.2. Улаанбурхан өвчний тархалтыг эрс бууруулах үйл ажиллагаанд хяналт тавих, ДЭМБ-ын НДББ-ээс дэвшүүлсэн улаанбурханы нутагшмал омгийн вирусийн тархалтыг таслан зогсоох шаардлагыг хангасан эсэх талаар үнэлгээ, дүгнэлт гаргах,

3.3. Улаанбурхан өвчний тандалтын шалгуур үзүүлэлт нь ДЭМБ-ын НДББ-ээс дэвшүүлсэн шаардлагын хэмжээнд хүрэхгүй эсвэл бүрэн бус байвал, өөрийн орны онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг боловсруулан бүсийн хороонд санал болгох,

3.4. Улаанбурхан өвчний тархалтыг эрс бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэн ДЭМБ-ын НДББ-ийн хороонд хүргүүлж байх,

3.5. Улаанууд өвчний тархалтыг хяналтад авах, төрөлхийн улаануудын хамшинжийн тандалтыг эрчимжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний явцыг хянан хэлэлцэж байх.